

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

2020.02.20 № 06/548
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Д.Баттогтох Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторов туслах Э.Төгөлдөр нар хэрэгжүүлэв.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/30 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол орны газарзүй, геоэкологийн онцлог, байгалийн хувьсал өөрчлөлт болон нийгэм-эдийн

засгийн хүчин зүйлс, газрын бүрхэвч, гадаргын болон гүний ус, цэвдэг, ой, хөрс зэрэг байгалийн нөөцийн төлөв байдлыг судалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шинжлэх ухааны үндэслэл, зөвлөмж боловсруулах, эрдэм шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгэхэд оршино.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Газарзүй, хөрс, ус, агаар, газар, ой, цөлжилт, цэвдэг судлал, газарзүйн мэдээллийн систем, зурагзүйн чиглэлээр онолын болон хэрэглээний судалгаа хийх, нийгэм эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах санал дэвшүүлэх.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 4.0” программ хангамж ашиглаж байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэх үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,591,942.0 мянган төгрөгөөс 51,838.8 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 51,838.8 мянган төгрөгөөр тооцсон нь тус хүрээлэнгийн орлого нь Улсын төсвийн санхүүжилтээс бүрдэх учир санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцох нь илүү бодитой гэж үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 151,058.5 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар

буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлагын үлдэгдэл өссөн бол урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	74,324.6	93,239.5	18,914.1
Урьдчилгаа	6,033.8	-	(6,033.8)
Бараа материал	42,046.0	26,431.3	(15,614.8)
Үндсэн хөрөнгө	2,783,675.6	2,783,134.0	(541.60)
Хуримтлагдсан элэгдэл	(674,958.9)	(822,337.9)	(147,378.87)
Биет бус хөрөнгө	580,759.1	558,080.1	(22,679.07)
Хуримтлагдсан элэгдэл	(23,500.7)	(1,226.0)	22,274.73
Нийт хөрөнгө	2,788,379.5	2,637,321.0	(151,058.5)
Өр төлбөр	12,753.4	-	(12,753.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,775,626.1	2,637,321.0	(138,305.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,788,379.5	2,637,321.0	(151,058.5)

Тайлант онд авлага 93,887.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 74,972.5 мянган төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдэл нь 18,914.1 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтээр Швейцарын хөгжлийн агентлаг болон Ачит Эх ХХК-тай хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, санхүүжилтийг тайлант оны эцэст нийт 93,239.5 мянган төгрөгийг хүлээн авсан боловч төслийн үйл ажиллагаанд хараахан зарцуулалт гараагүй тул буцаан төвлөрүүлж авлагаар бүртгэсэн нь нөлөөлжээ.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өмнөх оноос 6,033.8 мянган төгрөгөөр буурсан байна. Тус урьдчилж гарсан зардал нь 2012 оны 09 дүгээр сарын 01-ээс 2013 оны 05 дугаар сарын 29-ийг хүртэлх хугацаанд Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Хяналт шалгалтын акт, торгуулийн төлбөр байсан тул өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу өмнөх үеийн үр дүнд хаасан. Тайлант онд урьдчилж гарсан зардлын үлдэгдэл тайлагнаагүй байна.

Тайлант онд 106,398.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 122,013.4 мянган төгрөгийн бараа материалыг эрдэм шинжилгээ, лабораторын ажилд зарцуулсан байна. Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 15,614.8 мянган төгрөгөөр буурсан нь БНХАУ-ын Шинжлэх ухааны академтай хамтарсан “цөлжилтийг сааруулах, элсний нүүдлийг багасгах” төслийн үйл ажиллагаанд хэрэглэх бараа материалыг зарцуулсан нь гол нөлөөлөл болжээ.

Тайлант онд Эрдэм шинжилгээний зардлаас санхүүжүүлэн 28,188.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 3,180.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-4/1614 тоот зөвшөөрөлөөр худалдан авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 147,920.5 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны А-5/1240 тоот зөвшөөрөлөөр 31,910.3 мянган төгрөгийн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулж, хөрөнгийг бүртгэлээс хассан нь шатгаалжээ.

Тайлант онд Эрдэм шинжилгээний зардлаас санхүүжүүлэн 450.0 мянган төгрөгийн архивын программ худалдан авсан ба Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын

2019 оны А-2/2248 тоот зөвшөөрлөөр 23,129.1 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулж бүртгэлээс хассан нь шатгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд Үндэсний аудитын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/14 САГ-2019/51/СТД-ТШЗ албан шаардлагаар Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны 26 дугаар тогтоолоор Геоэкологийн хүрээлэн нь Газарзүйн хүрээлэнтэй нэгдэж Газарзүй, геоэкологийн хүрээлэн болон зохион байгуулагдсанаар алдаатай бүртгэгдсэн татварын авлага, өглөгийг харъяа татварын байгууллагатай тооцоо нийлж бүртгэлийг үнэн зөв гаргах албан шаардлага өгч тус шаардлагын дагуу өр төлбөрийг залруулга хийж тайлагнасан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд төлөгдөөгүй өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгатай холбоотойгоор 71,921.7 мянган төгрөгийн бичилт хийсэн байна. Үүнд:

- Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь Нийслэлийн зураг төслийн хүрээлэнтэй хамтран 2012.12.02-ны өдөр ТС1002/2012 тоот Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж Туул сэлбэ голуудын орчныг сэргээн сайжруулах Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг хийсэн боловч 69,500.0 мянган төгрөгийг аваагүй гэж бүртгэл тайланд авлагаар бүртгэсэн. Тус авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл удаа дараа гаргасан боловч 2019.06.07-ны өдрийн Чингэлтэй дүүргийн иргэний анхан шатны шүүхийн 182/ШШ2019/01068 дугаартай шийдвэрээр, тус авлагыг хэрэгсэхгүй болгосон тул өмнөх үеийн үр дүнд хаасан байна.
- Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны 26 дугаар тогтоолоор шинээр зохион байгуулагдснаар Газарзүй, геоэкологийн хүрээлэн болон өөрчлөгдсөнтэй холбоотой алдаатай бүртгэгдсэн байсан авлагын тооцоог шалгаж, холбогдох баримт материал, тооцоо нийлсэн актыг үндэслэн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирлын 2020.01.13-ны өдрийн А/02 тоот тушаалаар 2,421.7 мянган төгрөгийн авлагыг данснаас хасч өмнөх өмнөх үеийн үр дүнд хаасан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Газарзүй, геоэкологийн хүрээлэн 1,957,155.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,957,108.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Урсгал санхүүжилт

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	1,932,655.1	1,932,478.7	176.3	100.0%
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	24,500.0	24,630.0	(130.0)	100.5%
Нийт дүн	1,957,155.1	1,957,108.7	46.3	100.5%

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 130.0 мянган төгрөгөөр давсан нь хөрс болон усны шинжилгээний орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан технологийн хөтөлбөрт зориулан 1,957,108.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,957,108.7 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ. Нийт зардлын 1,932,478.7 мянган

төгрөгийг улсын төсвөөс, 24,630.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

Урсгал зардлын зарцуулалтыг зах зээлийн бодит үнэд суурьлан тэвчиж болох зардлыг хэмнэж төсвийн хэтрэлтгүй санхүүгийн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит этгээдийн хандив тусламжаар 118,787.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 259,599.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 189,887.0 мянган төгрөг, нийт 568,273.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Эрдэм шинжилгээний зардалд 475,034.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 93,239.5 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 38,336.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 20,582.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 17,753.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал:

Конторын барилгын элэгдлийн зардлыг 20,582.5 мянган төгрөгөөр дутуу тооцож алдаатай бүртгэл хөтөлсөн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчмыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 26 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 13 мэдээлэл оруулсан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 28 мэдээлэл оруулсан байна. Мэдээлээгүй болон хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16,328.6 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 3,750.0 мянган төгрөгийн зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

3.1.1 *Илрүүлэлт:*

Томилолтын мөнгийг Төрийн банкинд нээсэн виза картын дансанд шилжүүлдэг. Томилолтын 3,592.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ картын дансны орлого болон зардлын гүйлгээг мөнгөн хөрөнгийн данс гэж ангилан бүртгэлгүй шууд урьдчилж төлсөн тооцоо дансаар буруу ангилан бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 *Эрсдэл:*

Дансны ангилал буруу илэрхийлэгдэх;

3.1.3 *Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу зөв ангилан бүртгэх.

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 *Балансын данстай холбоотой асуудал*

3.2.1 *Илрүүлэлт:*

Тусгай зориулалтын материалын дансанд 4,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь

“Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгө болон бараа материалын дансны ангилал буруу, элэгдлийн зардал дутуу, санхүүгийн үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Тусгай зориулалтын материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн чанартай зүйлсийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан цалингийн зардал цалингийн хүснэгтээрх зардлын дүнгээс 2,548.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Тайлангийн уялдаа хангагдахгүй байх; Бүртгэл тооцооны зөрүү үүсэх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Бодогдсон нийт цалингийн дүнгээр цалингийн зардал бүртгэх, НДШ-ийн тайлан, цалингийн хүснэгт болон бусад уялдаа холбоо бүхий тайлан мэдээнүүдтэй тулгаж хяналт тавьж ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Орлогын данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн нийгмийн даатгалын өр төлбөрийн дүн нийгмийн даатгалын тайланд тайлагнасан дүнгээс 1,014.8 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 17.1.1-д “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалттай нийцэхгүй, “Иж бүрэн байх, эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн бүртгэл хөтлөлт болон нийгмийн даатгалын тайлангийн зөрүүний шалтгааныг тодруулж, холбогдох алдааг засч ажиллах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч данс бүртгэлийн дүнг холбогдох тайлан, мэдээний дүнтэй тулган шалгаж, хяналт тавьж ажиллана.

3.5. Орлогын данстай холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтээр хийгдэж байгаа төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны орлогоос ажиллагсдад олгосон цалингаас 6,298.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, төслийн төсөвт өртөгт тусгаагүй байна.

Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2-т “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” заавал даатгуулна гэсэн заалттай нийцээгүй, “Иж бүрэн байх, үнэлгээ ба хувиарлалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Төсөл хөтөлбөрийн зардлын төлөвлөгөөг хийхдээ цалин, түүнтэй адилтгах төлбөр тооцоотой холбоотойгоор гарах бүх төрлийн татвар, шимтгэлийг төсөвт өртөгт багтааж төлөвлөж байх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2020 оноос нэмэлт санхүүжилтийн төсвийг хийхдээ тус асуудлыг анхаарч төлөвлөгөөнд оруулж, төсөвт төвлөрүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>122,404,500.38</u>	<u>119,670,793.91</u>
33	АВЛАГА	<u>74,324,604.66</u>	<u>93,239,493.91</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,042,943.59	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	70,728,829.37	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	93,239,493.91
335	Бусад авлага	<u>1,552,831.70</u>	<u>00.00</u>
3351	Байгууллагаас авах авлага	1,552,831.70	00.00
34	УРЬДЧИЛГАА	<u>6,033,820.72</u>	<u>00.00</u>
34600	Урьдчилж гарсан зардал	6,033,820.72	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>42,046,075.00</u>	<u>26,431,300.00</u>
351	Түүхий эд материал	<u>31,898,300.00</u>	<u>24,852,200.00</u>
35110	Тусгай зориулалттай материал	31,898,300.00	24,852,200.00
354	Хангамжийн материал	<u>10,147,775.00</u>	<u>1,579,100.00</u>
35410	Бичиг хэргийн материал	759,750.00	734,700.00
35420	Аж ахуйн материал	1,032,220.00	194,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	770,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	350,000.00	380,000.00
35450	Барилгын засварын материал	1,980,711.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	5,255,094.00	269,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,665,975,020.95</u>	<u>2,517,650,223.05</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2,665,975,020.95</u>	<u>2,517,650,223.05</u>
392	Биет хөрөнгө	<u>2,108,716,607.54</u>	<u>1,960,796,142.93</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,856,422,808.30	1,856,422,808.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,075,590.72)	(99,092,794.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,476,124.00	66,476,124.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,476,124.00)	(66,476,124.00)
39205	Машин тоног төхөөрөмж	571,937,001.63	578,444,854.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	(376,073,872.76)	(445,721,874.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	214,785,168.35	207,286,419.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(169,862,423.47)	(168,571,597.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,586,060.00	48,586,060.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,470,976.36)	(42,475,465.44)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,600,000.00	3,600,000.00
39217	Ном	21,868,432.57	22,317,732.57
393	Биет бус хөрөнгө	<u>557,258,413.41</u>	<u>556,854,080.12</u>
39301	Програм хангамж	24,663,067.00	1,984,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(23,500,733.59)	(1,225,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	556,096,080.00	556,096,080.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,788,379,521.33</u>	<u>2,637,321,016.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,753,448.72</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>12,753,448.72</u>	<u>00.00</u>
413	Өглөг	<u>12,753,448.72</u>	<u>00.00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	11,117,348.72	00.00
4136	Бусад өглөг	<u>1,636,100.00</u>	<u>00.00</u>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,636,100.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,775,626,072.61</u>	<u>2,637,321,016.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>2,775,626,072.61</u>	<u>2,637,321,016.96</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,741,521,060.73	1,741,521,060.73
51101	Өмч: - төрийн	1,741,521,060.73	1,741,521,060.73
512	Хуримтлагдсан үр дүн	<u>(779,809,956.00)</u>	<u>(918,115,011.65)</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	(714,446,018.96)	(851,731,617.07)
51220	Тайлант үеийн үр дүн	(65,363,937.04)	(66,383,394.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,813,914,967.88	1,813,914,967.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,788,379,521.33</u>	<u>2,637,321,016.96</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,000,185,329.61	2,525,558,682.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,281,458.70	24,630,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	65,281,458.70	24,630,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,281,458.70	24,630,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,838,300.00	24,630,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,443,158.70	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,934,903,870.91	2,500,928,682.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,616,133,900.00	1,932,655,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,616,133,900.00	1,932,655,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	318,769,970.91	568,273,582.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	118,787,582.60
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	69,753,220.91	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	235,475,500.00	259,599,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,541,250.00	189,887,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,065,549,266.65	2,591,942,077.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,065,549,266.65	2,591,942,077.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044,453,111.99	2,586,090,379.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,367,273,774.00	1,635,552,105.00
210101	Үндсэн цалин	1,348,027,866.00	1,431,181,379.00
210102	Нэмэгдэл	-	122,001,126.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	82,369,600.00
210104	Урамшуулал	7,170,800.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	12,075,108.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,023,737.88	206,797,626.88
210201	Тэтгэврийн даатгал	108,590,372.53	142,696,062.88
210202	Тэтгэмжийн даатгал	16,489,305.46	16,215,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,751,254.00	12,972,615.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,622,646.00	3,152,474.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,570,159.89	31,760,704.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,432,818.00	46,500,688.00
210301	Гэрэл, цахилгаан	16,995,871.00	20,975,231.00
210302	Түлш, халаалт	25,654,106.00	20,897,100.00
210303	Цэвэр, бохир ус	3,782,841.00	4,628,357.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,327,820.14	95,914,652.40
210401	Бичиг хэрэг	8,581,835.00	22,079,330.40
210402	Тээвэр, шатахуун	8,382,000.00	4,940,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,592,651.00	2,459,856.00
210404	Ном, хэвлэл	3,950,279.14	3,056,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,181,165.00	30,618,166.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,079,890.00	31,200,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,344,498.00	30,158,922.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,315,000.00

Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	43,344,498.00	26,843,922.00
2107	Томилолт, зочны зардал	47,002,700.00	858,210.00
210701	Гадаад албан томилолт	8,219,500.00	-
210702	Дотоод албан томилолт	38,783,200.00	858,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	193,965,752.86	385,734,077.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	188,672,672.86	378,470,453.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	307,368.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	364,580.00	533,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	73,000.00
210807	Газрын төлбөр	1,936,800.00	3,849,756.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,082,011.11	184,574,097.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,839,300.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	887,200.00	4,430,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	135,355,511.11	180,143,497.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,096,154.66	5,851,698.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,404,300.00	5,675,352.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,404,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,675,352.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,691,854.66	176,346.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,691,854.66	176,346.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(65,363,937.04)	(66,383,394.58)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(65,363,937.04)	(66,383,394.58)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,977,181,830.94	2,525,558,682.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,838,300.00	24,630,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,838,300.00	24,630,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,838,300.00	24,630,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,838,300.00	24,630,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,942,343,530.94	2,500,928,682.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,616,133,900.00	1,932,655,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,616,133,900.00	1,932,655,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	326,209,630.94	568,273,582.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	118,787,582.60
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	69,753,220.91	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	242,915,160.03	259,599,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,541,250.00	189,887,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,953,640,175.94	2,493,739,982.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,953,640,175.94	2,493,739,982.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,932,544,021.28	2,392,424,142.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,366,254,741.28	1,576,376,398.00
210101	Үндсэн цалин	1,352,905,271.28	1,486,852,318.00
210102	Нэмэгдэл	-	61,044,360.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,479,720.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,349,470.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,844,044.00	204,507,300.00
210201	Тэтгэврийн даатгал	115,853,944.00	119,928,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,996,700.00	33,866,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,751,254.00	14,070,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,245,446.00	14,070,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,996,700.00	22,570,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,432,818.00	46,434,488.00
210301	Гэрэл, цахилгаан	17,118,221.00	18,809,116.00
210302	Түлш, халаалт	25,654,106.00	22,997,015.00
210303	Цэвэр, бохир ус	3,660,491.00	4,628,357.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,705,546.00	12,451,200.00
210401	Бичиг хэрэг	5,589,570.00	2,172,890.40
210402	Тээвэр, шатахуун	2,853,000.00	2,399,877.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,521,101.00	2,230,879.00
210404	Ном, хэвлэл	3,625,700.00	1,996,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560,000.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,556,175.00	2,091,153.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,775,950.00	30,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	700,000.00	-
210604	Урсгал засвар	30,075,950.00	30,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	43,569,377.00	22,302,500.00

210701	Гадаад албан томилолт	10,361,500.00	-
210702	Дотоод албан томилолт	33,207,877.00	22,302,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	263,171,045.00	496,352,256.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,877,965.00	490,497,888.69
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	326,700.00	307,368.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	364,580.00	467,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	139,000.00
210807	Газрын төлбөр	1,936,800.00	2,440,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,790,500.00	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,839,300.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	951,200.00	4,000,000.00
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,096,154.66	101,315,839.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,404,300.00	7,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,404,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,691,854.66	93,415,839.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,131,657.72	176,346.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	560,196.94	93,239,493.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>23,541,655.00</u>	<u>31,818,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,547,250.00	31,818,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,547,250.00	31,818,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,547,250.00	31,818,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,547,250.00	31,818,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(23,547,250.00)</u>	<u>(31,818,700.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(5,595.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,595.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /				
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	(699,320,818.96)	880,007,478.72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(15,125,200.00)	(15,125,200.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,185,424,980.73	393,903,316.95	(714,446,018.96)	864,882,278.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	556,096,080.00	-	(65,363,937.04)	490,732,142.96
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(779,809,956.00)	2,775,626,072.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(71,921,661.07)	(71,921,661.07)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(851,731,617.07)	2,703,704,411.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(66,383,394.58)	(66,383,394.58)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(918,115,011.65)	2,637,321,016.96

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,957,155,100.00	1,957,108,754.00	46,346.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,957,155,100.00	1,957,108,754.00	46,346.00	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,949,255,100.00	1,949,208,754.00	46,346.00	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,576,376,400.00	1,576,376,398.00	2.00	100.0
Үндсэн цалин	1,442,767,800.00	1,486,852,318.00	(44,084,518.00)	103.1
Нэмэгдэл	75,795,800.00	61,044,360.00	14,751,440.00	80.5
Унаа хоолны хөнгөлөлт	57,812,800.00	28,479,720.00	29,333,080.00	49.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,507,300.00	204,507,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	144,150,500.00	119,928,900.00	24,221,600.00	83.2
Тэтгэмжийн даатгал	15,089,200.00	33,866,600.00	(18,777,400.00)	224.4
ҮОМШӨ-ний даатгал	12,071,400.00	14,070,600.00	(1,999,200.00)	116.6
Ажилгүйдлийн даатгал	3,017,800.00	14,070,600.00	(11,052,800.00)	466.3
Эрүүл мэндийн даатгал	30,178,400.00	22,570,600.00	7,607,800.00	74.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,434,500.00	46,434,488.00	12.00	100.0
Гэрэл, цахилгаан	16,256,000.00	18,809,116.00	(2,553,116.00)	115.7
Түлш, халаалт	26,614,500.00	22,997,015.00	3,617,485.00	86.4
Цэвэр, бохир ус	3,564,000.00	4,628,357.00	(1,064,357.00)	129.9
Хангамж, бараа материалын зардал	12,882,000.00	12,882,000.00	-	100.0
Бичиг хэрэг	3,500,000.00	2,172,890.40	1,327,109.60	62.1
Тээвэр, шатахуун	1,200,000.00	2,399,877.00	(1,199,877.00)	200.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,480,000.00	2,230,879.00	1,249,121.00	64.1
Ном, хэвлэл	1,500,000.00	2,427,200.00	(927,200.00)	161.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	1,560,000.00	40,000.00	97.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,602,000.00	2,091,153.60	(489,153.60)	130.5
Эд хогшил, урсгал засварын зардал	32,750,000.00	32,750,000.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	2,750,000.00	2,750,000.00	-	100.0
Урсгал засвар	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
Томилолт, зочны зардал	22,302,500.00	22,302,500.00	-	100.0
Дотоод албан томилолт	22,302,500.00	22,302,500.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,002,400.00	49,956,068.00	46,332.00	99.9
Бусдаар	44,102,700.00	44,101,700.00	1,000.00	100.0

гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж				
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	326,700.00	307,368.00	19,332.00	94.1
Тээврийн хэрэгслийн татвар	467,500.00	467,500.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	139,000.00	26,000.00	84.2
Газрын төлбөр	2,440,500.00	2,440,500.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,900,000.00	7,900,000.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	7,900,000.00	7,900,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,900,000.00	7,900,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,957,155,100.00	1,957,108,754.00	46,346.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,932,655,100.00	1,932,478,754.00	176,346.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,932,655,100.00	1,932,478,754.00	176,346.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,500,000.00	24,630,000.00	(130,000.00)	100.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,500,000.00	24,630,000.00	(130,000.00)	100.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	158	158	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	133	133	-	100.0
Үйлчлэх ажилтан	24	24	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	-

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/ төгрөгөөр /
			Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		568,273,582.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ		475,034,088.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		475,034,088.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		475,034,088.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		475,034,088.69
213305	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		93,239,493.91
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт		93,239,493.91
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		568,273,582.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		568,273,582.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		118,787,582.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		259,599,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		189,887,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.21			САГ-2020/165/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Газарзүй, геоэкологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нэмэлт санхүүжилтээр хийгдэж байгаа төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны орлогоос ажилчдад олгосон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, төслийн төсөвт өртөгт тусгаагүй байна. Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 2-т “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” заавал даатгуулна гэсэн заалттай нийцээгүй, “Иж бүрэн байх, үнэлгээ ба хувиарлалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	6,298.7	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Баттогтох
2	Нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн нийгмийн даатгалын өр төлбөрийн дүн нийгмийн даатгалын тайланд тайлагнасан дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 17.1.1-д “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалттай нийцэхгүй, “Иж бүрэн байх, эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1,014.8	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Баттогтох

3	Тусгай зориулалтын материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.	4,300.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Баттогтох
4	Томилолтын мөнгийг Төрийн банкинд нээсэн виза картын дансанд шилжүүлдэг. Уг томилолттой холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ картын дансны орлого болон зардлын гүйлгээг мөнгөн хөрөнгийн данс гэж ангилан бүртгэлгүй шууд урьдчилж төлсөн тооцоо дансаар буруу ангилан бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцэхгүй, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	3,592.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Баттогтох
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан цалингийн зардал цалингийн хүснэгтээрх зардлын дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	2,548.2	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Баттогтох
	Зөвлөмжийн дүн	17,753.7			